

## НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

**Огноо:** 2019.03.15

**Тендер шалгаруулалтын нэр:** Түлхүүр гардуулах гэрээгээр хэрэгжих “Цахилгаан дамжуулах агаарын шугамын модон тулгуурыг төмөр бетоноор шинэчлэх /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5, 14 дүгээр хороо/”

**Тендер шалгаруулалтын дугаар:** ЭХЯ/201912018

Эрчим хүчний яам эрх бүхий тендерт оролцогчдоос Түлхүүр гардуулах гэрээгээр хэрэгжих “Цахилгаан дамжуулах агаарын шугамын модон тулгуурыг төмөр бетоноор шинэчлэх /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 4, 5, 14 дүгээр хороо/” ажлыг гүйцэтгэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь худалдан авах ажиллагааны цахим системээр зарлагдаж байгаа тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу. Тендерт оролцохын тулд эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар цахим тендерийн хураамж төлнө.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- *Борлуулалтын хэмжээ:*  
Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 онуудын аль нэг жилд борлуулалтын орлогын хэмжээ нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас багагүй байна.
- *Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:*  
Тухайн багцын төсөвт өртгийн 70 хувиас багагүй байна.
- *Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх:*  
0.4-110 кВ /03.9.3/ цахилгаан дамжуулах шугам, дэд станцын ТЭЗҮ, зураг, төсөл боловсруулах /Эрчим хүчний яам/, 0.4-10 кВ /03.2.1/ ба түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан түгээх шугам, дэд станцын угсралт, засвар, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээний тусгай зөвшөөрөлтэй байна /Эрчим хүчний яам/

Тендерийн хамт 3,000,000 төгрөгийн үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 16:00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 16:30 цагт нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

17060 Улаанбаатар хот. Хан-Уул дүүрэг.  
Чингисийн өргөн чөлөө. Эрчим хүчний яам.  
Засгийн газрын XIY байр. 3 давхар. 306 тоот өрөө.  
Утас: 62263072  
[www.energy.gov.mn](http://www.energy.gov.mn)